

Засгийн газраас баталсан “**Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр**”-ийн  
хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

2009 оны эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл									
	Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо	2003 оны 6-р сарын 24-ний 160-р тогтоол									
1.	Хөтөлбөрийн зорилго	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх замаар олон улсын жишиг, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, импортыг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.									
2.	Хөтөлбөрийн зорилтууд: /үе шатны, хугацаатай нь авч үзэх/	I үе шат 2003-2008 он Эрчимжсэн мал аж ахуйг бүсийн тулгуур төвүүдийг түшиглэн байгуулахад дэмжлэг үзүүлэх.		Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн орчинг сайжруулах.							
		II үе шат 2009-2015 он Бүсийн тулгуур төвүүдийг түшиг-лэсэн эрчимжсэн аж ахуйг өргөжүүлэх, орон нутгийн хөгжлийн төвүүдийг түшиглэн хөгжүүлэх		Эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, загвар нэгж бий болгож өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.							
				Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.							
3.	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/									
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/, үүнээс		658.400.000							
		Тухайн жилд зарцуулсан		Хөтөлбөрийн хүрээнд 2009 онд хөнгөлөлттэй зээл, эргэн төлөгдөх мал амьтныг мөнгөн дүнд шилжүүлсэнээр 1073,3 сая төгрөг зарцуулсан							
4.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь		Нийт	100	90	70	50	30	10	0
		Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын тоо		3			2	1			
5.	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл		<b>Төлөвлөсөн</b>			<b>Гүйцэтгэл</b>				<b>Хувь</b>	
	Шалгуур үзүүлэлт тус бүрээр	1. Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх таатай орчин бүрдүүлэх зорилгоор эрх бүхий байгууллагаас хөтөлбөрийн дагуу гаргасан эрх зүйн баримт бичгүүд, түүний хэрэгжилт	Үндэсний стандарт, технологийн зөвлөмж батлуулан мөрдүүлэх.			Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа, тэдэнд үзүүлэх мэргэжлийн үйлчилгээнд шаардлагатай үндэсний 7 стандартыг, Стандартын техникийн хороогоор, технологийн 3 зөвлөмжийг МAAЭШХ-ийн эрдмийн зөвлөлөөр тус тус				100 %	

			батлуулан мөрдүүлж байна.	
	2. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд бизнесийн болон технологийн мэдлэг олгох чиглэлээр зохион байгуулсан сургалт, үзүүлэх сургууль, тэдгээрт хамрагдсан хүний тоо	3-н удаагийн сургалт зохион байгуулах	“Бод, бог малын зохиомол хээлтүүлгийн технологич бэлтгэх” сургалтанд ТӨ, ДА, СЭ, БУ, ХЭ аймгуудаас 35 хүнийг, сүү махны хосолмол ашиг шимтэй Норманд үүлдрийн үхрийг цэврээр өсгөх зорилгоор зохион байгуулсан “Хөврөл суулгах арга” үзүүлэх сургуулилтад МААЭШХ, МУСҮТ, бусад ААН-ийн 20 мэргэжилтнийг, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, Сүү-2 төсөлтэй хамтран Израйлийн ОУ-ын байгууллага МАШАВ-ын хоёр мэргэжилтнийг урьж зохион байгуулсан 3 өдрийн сургалтад 25 фермерийг, “Мах, сүүний үхрийн аж ахуй эрхлэгчдэд зориулсан мэргэшүүлэх сургалт”-д хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг авсан 30 аж ахуй төлөөллийг тус тус оролцуулан нийт 110 хүнийг сургаж дадлагажуулсан.	100 %
	3. Бүсийн тулгуур төвүүдийн ойролцоо байгуулагдсан загвар болон эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж, шинээр бий болсон фермерүүдийн тооны өсөлт	Фермерийн аж ахуйн тоог 2-3 хувиар өсгөх	Хот суурин газрын хүн амыг аюулгүй хүнс тэжээлээр хангах хэрэгцээ шаардлагын улмаас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр засгаас ихээхэн анхаарч байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд энэ чиглэлийн бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдсээр байна. 2009-оны байдлаар байдлаар улсын хэмжээнд 1035 эрчимжсэн аж ахуй үйл	100 %

			ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оныхтой харьцуулахад фермерийн аж ахуйн тоо 55 буюу 3.5 хувиар нэмэгдсэн байна.	
	4. Улсын нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийн жин, нэгжээс авах ашиг шимийн өсөлт	Цэвэр эрлийз малын тоог 2,0 саяд хүргэх	Цэвэр эрлийз малын тоо өссөн ч нийт малд эзлэх хувийн жин нэмэгдээгүй, энэ нь сүүлийн жилүүдэд нутгийн малын тоо эрс өссөнтэй холбоотой байна.	50 %
	5. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн орлого болон амжиргааны түвшингийн өсөлт	Эрчимжсэн МАА эрхлэгчдийн орлогын судалгаа хийх.	Судалгаа хийгдээгүй	0 %
	6. Мах, сүү, өндөг зэрэг бүтээгдэхүүний өсөлт, махны экспорт болон мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортын хэмжээ	Мах, сүү, өндөг зэрэг бүтээгдэхүүний импортын тоо хэмжээг бууруулна.	Бүтээгдэхүүний дотоод зах зээл дэх борлуулалтыг дэмжих талаар хангалттай ажиллаж чадаагүй тул импортоор орж ирж буй бүтээгдэхүүний хэмжээ буураагүй байна.	0 %
	7. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний өсөлт, бууралт, хөрөнгө оруулалтын нийгмийн үр ашиг болон иргэдийн санал, гомдлын байдал	2009 онд 1,2 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.	Хөтөлбөрийн хүрээнд 2009 онд 48 иргэн аж ахуйн нэгжид 582 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлийг 3 жилийн хугацаатай, жилийн 5 хувийн хүүтэй, 53 иргэн, аж ахуйн нэгжид 438.9 сая төгрөгний үнэ бүхий 281 толгой арвин ашиг шимтэй үржлийн өсвөр үхэр, 19.8 сая төгрөгний үнэ бүхий 33 толгой үржлийн өсвөр гахайг 33 иргэн аж ахуйн нэгжид, 29.5 сая төгрөгний үнэ бүхий 12000 дэгдээхэйг 7 аж ахуйн нэгжид тус тус эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гэрээ хийж олгосон. Үүнийг мөнгөн дүнд шилжүүлж үзвэл 1073,3 сая төгрөг зарцуулсан байна.	89,4 %
	8. Эрчимжсэн АА эрхлэгчдэд газрыг урт хугацаагаар ашиглуулсан болон эзэмшүүлсэн	Газрыг урт хугацаагаар ашиглуулах, эзэмшүүлэх зохистой	13 аймгийн 96 сумын нутаг дэвсгэрт эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд	100 %

		байдал	хувилбарыг олж нэвтрүүлэх	хадлангийн болон бэлчээрийн зориулалттай 160.0 мянган га газрыг урт хугацаагаар эзэмшүүлэх ажлыг орон нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран гүйцэтгэж гэрээ хийсэн.	
		9. ЭМАА-н чиглэлээр хэрэгжүүлсэн гадаад орон, ОУБ-ын төслүүд, түүний үр нөлөө	ОУБ-ын төсөл эхлүүлэх үндэслэлийг судлан санал боловсруулах	2009 оны 6-р сард ХХААХҮ-ийн сайд Канад улсад айлчилж Канадын ХХАА-н сайдтай санамж бичигт гарын үсэг зурсаны дагуу Нийслэлийн ойролцоо сүүний чиглэлийн ферм, Монгол-Канадын хамтарсан загвар аж ахуй байгуулах төсөл боловсруулан гадаад харилцааны хэлтсээр дамжуулан санал солилцож байна.	30,0 %
		<b>Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж</b>			63,3 %
6.	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа, гарц	<p>- Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа, тэдэнд үзүүлэх мэргэжлийн үйлчилгээнд шаардлагатай үндэсний 7 стандартыг Стандартын техникийн хороогоор, технологийн 3 зөвлөмжийг МААЭШХ-ийн эрдмийн зөвлөлөөр тус тус батлуулан мөрдүүлж байна.</p> <p>- “Малын үзэсгэлэн худалдааны яармаг, захын зураг төсөв боловсруулах” тухай тендерт шалгарсан “БИ ЦЭ” ХХК –тай гэрээ байгуулан Малын биржийн зураг төсөл, Малын биржийн ерөнхий схем, Эмээлт өртөөнд олгосон газрын байршлын зураг, төсөв зохиолгосон. - Сүү, махны төрөлжсөн үүлдрийн өсвөр үхэр худалдан авах тендерт шалгарсан Нийслэлийн ХУД-ийн “Өрнөх дэвжих” ХХК-аас Сүүний чиглэлийн Хар тарлан үүлдрийн үржлийн 75 толгой өсвөр үнээ, Хэнтий аймгийн Биндэр сумын “Ган сумч” ХХК-аас Сүү-махны чиглэлийн үржлийн шар тарлан үүлдрийн 145 өсвөр үхрийг тус тус хүлээн авч нийлүүлсэн.</p> <p>- Сүү, сүү махны үхрийн эрчимжсэн аж ахуйг Улаанбаатар хот болон бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төвийн ойролцоо нутагт үржүүлэх зорилгоор 22 аймаг, нийслэлээс үржлийн арвин ашиг шимтэй өсвөр үнээ хүссэн 275 төслөөс сонгон шалгаруулалт хийж, төслийн шаардлага хангасан УБ хот, ӨВ, БӨ, БУ, ГО, ТӨ, СЭ, ОР, ХЭ аймгуудын 36 иргэн, 9 аж ахуйн нэгжид Шар тарлан үүлдрийн 149 толгой, Хар тарлан үүлдрийн 75 толгой үхрийг 5 жилийн хугацаатай 18-24 сарын настай өсвөр гунжаар эргэн төлөх нөхцөлтэй гэрээ байгуулан олгох ажлыг зохион байгуулсан. /Тендер шалгаруулалтад 345.0 сая төг зарцуулсан/</p> <p>- Сүү, махны чиглэлийн төрөлжсөн мал болон гахай, шувууны фермерийн аж ахуй байгуулах төслийг сонгон шалгаруулж Төвийн бүсэд сүү, махны үхэр, махны хонь, гахай, тахиа болон зөгийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн санхүүгийн дэмжлэг хүсэж ирүүлсэн 185 төслөөс сонгон шалгаруулалт хийж, хангасан төсөл</p>			

		<p>ирүүлсэн УБ хот, АР, БӨ, БУ, ДА, ОР, УВ, СҮ СЭ, ТӨ, ХО, ХЭ, ХӨ, ЗА, ДО, ӨМ, ӨВ, ГО аймгуудын 19 иргэн, 18 ААН-д 3 жилийн хугацаатай жилийн 5 хувийн хүүтэй 302,0 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулан олгосон.</p> <p>- Төвийн бүсэд сүүний үхэр, махны хонины эрчимжсэн фермерийн аж ахуйн цогцолбор байгуулахад зориулан Төв аймгийн Баянчандмань сумын “Баянчандмань тур” ХХК-ний ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж 100,0 сая төгрөгийг 3 жилийн хугацаатай хүүгүй олгосон.</p> <p>- Төвийн бүсэд нарийн нарийвтар ноост хонины эрчимжсэн фермерийн аж ахуй байгуулахад зориулан 5 иргэн, аж ахуйн нэгжийн ирүүлсэн төслөөс сонгон шалгаруулалт хийж, шаардлага хангасан төсөл ирүүлсэн Төв аймгийн Мөнгөнморьт сумын “Босго халдуун” хоршоонд 150,0 сая төгрөгийг 5 жилийн хугацаатай хүүгүй олгосон.</p> <p>- Сүү, махны чиглэлийн төрөлжсөн мал болон гахай, шувууны фермерийн аж ахуй байгуулах зорилгоор МЭҮГ-т ирүүлсэн 13 иргэн, аж ахуйн нэгжийн төслөөс сонгон шалгаруулалт хийж, шаардлага хангасан төсөл ирүүлсэн 5 иргэн, 1 аж ахуйн нэгжид 30 сая төгрөгийг 3 жилийн хугацаатай жилийн 3 хувийн хүүтэй олгосон.</p> <p>- Хоногийн настай дэгдээхэй зээлээр авч үйлдвэрлэлээ өргөтгөх хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн 11 төслөөс шаардлага хангасан 7 аж ахуйн нэгжийн төслийг шалгаруулж, тус бүрд нь Родинот-2 үүлдрийн хоногийн настай 2000 дэгдээхэй, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын “Ундрах цэг” ХХК-д 1500 дэгдээхэй, УБ хотын Хүнсний технологийн коллежид 500 дэгдээхэйг тус тус олгосон. /Гендерт 25,5 сая төгрөг зарцуулсан/</p>
7.	Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/	<p>- 2005 онд саалийн 244 толгой үнээтэй байсан бол хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд 2009 онд 19,3 мянган саалийн үнээтэй болж нэмэгдсэн байна.</p> <p>- Фермерүүдэд ажиллаж байгаа иргэн , аж ахуйн нэгжүүдийн орлого жилээс жилд нэмэгдэж байна.</p> <p>- Гахайн фермийн тоо нэмэгдэж, үйл ажиллагаа нь тогтворжин зах зээлд нийлүүлэх махны хэмжээ эрс өссөн.</p>
8.	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал	<p>Төслүүдийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавихад орон нутгийн мэргэжлийн байгууллагын оролцоо муу байгаагаас эргэн төлөгдөж байгаа малын чанар гэрээнд заасан шалгуур стандартуудыг хангадгүй. Үүнээс үүдээд дараагын мал амьтан олгох ажилд бэрхшээл учирч байна.</p> <p>2.Зээл болон үржлийн мал амьтан олгох үйл ажиллагаа нь зарим талаар эзнээ олдоггүй зориулалтын бусаар зарцуулагддаг нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтэнд хүндрэл учруулдаг.</p> <p>3. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зах зээлийн хэрэгцээ их байгаа хэдийч төрөөс аж ахуй эрхлэгчдэд үзүүлж байгаа санхүүгийн болон арвин ашиг шим бүхий үржлийн мал олгох дэмжлэгийн цар хүрээ бага байгаа нь хөтөлбөрийн бодит үр дүнг бууруулахад хүргэж байна. Иймд дэмжлэгийг бодит эзэнд нь хүргэх, тэдгээртэй хариуцлага тооцох оновчтой механизмыг бий болгох явдал чухал байна.</p>
9.	Эдгээрээс гарах арга зам	Өнгөрсөн хугацаанд хөтөлбөрийн хэрэгжилт тухайн жилдээ төлөвлөсөн үр дүнд хүрч байсан. Гэвч зах зээлийн хөгжлийн явцад гарч буй шинэ эрэлт хэрэгцээг хангах, аж ахуй эрхлэхэд учирч буй

		<p>хүндрэл зэрэг тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, зарцуулсан хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг сайжруулах шаардлага тулгарч байгаа тул дор дурьдсан саналыг дэвшүүлж байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Эрчимжсэн МАА хөгжлийг тогтвортой байлгах үүднээс аж ахуй эрхлэгчдэд газар, бэлчээрийг өмчлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх</li> <li>2. Зээл болон мал, амьтны эргэн төлөлтийг “Мал хамгаалах сан”-д төвлөрүүлэх асуудлыг эрх зүйн хувьд баталгаажуулах</li> <li>3. Эрчимжсэн МАА хөгжилд үзүүлж буй дэмжлэгийг бодитой болгох зорилгоор фермерийн статусыг эрх зүйн хувьд тодорхойлох</li> <li>4. Санхүүгийн ба эргэн төлөгдөх нөхцлөөр мал, амьтны дэмжлэг авсан аж ахуйн нэгж, иргэний талаарх мэдээллийн нэгдсэн санг бий болгох</li> <li>5. Зээлийн гэрээний механизмыг боловсронгуй болгож, төслүүдийн хэрэгжилт, үр дүнг тооцох, хяналт тавихад орон нутгийн засаг захиргааны болон мэргэжлийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх</li> <li>6. Эргэн төлөгдөж байгаа малын чанарт тавих хяналтыг сайжруулах</li> <li>7. Аж ахуй эрхлэгчдийн бизнес, аж ахуй эрхлэлт, технологийн ур чадварыг дээшлүүлэх</li> <li>8. Хөтөлбөрийн хүрээнд үзүүлж буй дэмжлэгийг экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд чиглүүлэх</li> </ol>
10	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ	<p>Хөтөлбөр нь нийгмийн шаардлагын үүднээс урган гарч мал аж ахуйн үлдвэрлэл эрхлэгчдийн таашаалд нийцсэн хот суурин газрын хүн амыг хүнсээр хангахад ихээхэн хувь нэмрээ оруулсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг эрх зүй, эдийн засаг болоод чадвахи бэхжүүлэхэд нь чухал ач холбогдолтой болжээ. Энэ хөтөлбөрийн үр шимийг хүртэгчдийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа хэдий ч төрөөс аж ахуй эрхлэгчдэд үзүүлж байгаа санхүүгийн болон арвин ашиг шим бүхий үржлийн мал олгох дэмжлэгийн цар хүрээ бага байгаа нь хөтөлбөрийн бодит үр дүнг бууруулахад хүргэж байна</p>
11	Хөтөлбөрийн талаарх яамны санал /өөрчлөн сайжруулах болон бодлогод үзүүлж буй хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх талаар гэх мэт/	<ol style="list-style-type: none"> <li>1. Хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн ба эргэн төлөгдөх нөхцлөөр мал, амьтны дэмжлэг авсан аж ахуйн нэгж, иргэний талаарх мэдээллийн нэгдсэн санг бий болгох, зээлийн гэрээний механизмыг боловсронгуй болгож, төслүүдийн хэрэгжилт, үр дүнг тооцох, хяналт тавихад орон нутгийн засаг захиргааны болон мэргэжлийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, эргэн төлөгдөж байгаа малын чанарт тавих хяналтыг сайжруулах, аж ахуй эрхлэгчдийн бизнес, аж ахуй эрхлэлт, технологийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх, Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зах зээлийн хэрэгцээ их байгаа хэдийч төрөөс аж ахуй эрхлэгчдэд үзүүлж байгаа санхүүгийн болон арвин ашиг шим бүхий үржлийн мал олгох дэмжлэгийн цар хүрээ бага байгаа нь хөтөлбөрийн бодит үр дүнг бууруулахад хүргэж байна. Иймд дэмжлэгийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.</li> </ol>
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн	<p>Хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгоход орон нутгийн ХХААЖДҮГ-ын оролцоо маш бага тул ямар иргэн аж ахуйн нэгж дэмжлэг авсан, ямар үйл ажиллагаа явуулж байгаа</p>

төрийн байгууллагуудын оролцооны талаарх санал /дэд хөтөлбөртэй байх, тухайн аймагт заавал хэрэгжүүлэх шаардлага байгаа эсэх гэх мэт/	талаар мэдээлэлгүй, хэрэгжилтийг орон нутгаас хянах тогтолцоо ажиллагдаггүй. Сумдууд болон аймагт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөдөг, тайлагнадаг, дүгнэдэг, төрийн захиргааны төв байгууллагад мэдээлдэг тогтолцоо бий болж чадаагүй.
---	---

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА